



НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

“ДАВС БАГАТАЙ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ, ХЭРЭГЛЭЭГ НЭМЭГДҮҮЛЭХ” КОМПАНИТ АЖЛЫН ТАЙЛАН



Улаанбаатар хот
2020 он



Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв

САНХҮҮЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГА

ЭМЯ, Эрүүл мэндийг дэмжих сан

ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГА

Нийгмийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв

ТАЙЛАН БИЧСЭН:

Б.Энхтунгалаг, НЭМҮТ-ийн Хоол судлалын албаны ЭША

ТАЙЛАН ХЯНАСАН:

Д.Нарантуяа, НЭМҮТ-ийн Ерөнхий захирал, АУ-ны доктор

Ж.Батжаргал, НЭМҮТ-ийн Хоол судлалын албаны дарга, АУ-ны доктор



ТОВЧИЛСОН ҮГ, ХЭЛЛЭГИЙН ТАЙЛБАР

ААН	Аж ахуйн нэгж
АУ	Анагаах ухаан
БГД	Баянгол дүүрэг
БХЯ	Батлан хамгаалах яам
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
МҮХАҮТ	Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхим
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
МУ	Монгол улс
МХЭАХННХ	Монголын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгүүдийн нэгдсэн холбоо
НБГ	Нийслэлийн боловсролын газар
НЗАА	Нийслэлийн Захирагчийн ажлын алба
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
НХХААГ	Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар
НЭМҮТ	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
НЭМГ	Нийгмийн эрүүл мэндийн газар
СХД	Сонгинохайрхан дүүрэг
ХК	Хувьцаат компани
ХҮБХЗГ	Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар
ХСА	Хоол судлалын алба
ХУД	Хан-Уул дүүрэг
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
УБЗАА	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба



Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв

УБТЗ	Улаанбаатар төмөр зам
ШУТИС	Шинжлэх ухаан технологийн их сургууль
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМХХ	Эрүүл мэндийн хяналтын хэлтэс
ЭМЯ	Эрүүл мэндийн яам



Агуулга

НЭГ. ҮНДЭСЛЭЛ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА.....	1
ХОЁР. ЗОРИЛГО, ЗОРИЛТ	1
ГУРАВ. ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА	2
3.1. МЭДЭЭЛЭЛ, СУРТАЛЧИЛГААНЫ МАТЕРИАЛ ХЭВЛҮҮЛЭХ, ТҮГЭЭХ.....	2
3.2. “ДАВС БАГАТАЙ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖЬЕ”	4
АРГА ХЭМЖЭЭНД ОРОЛЦОЖ БУЙ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГУУДАД	4
ХИЙСЭН СУРГАЛТ, МЭДЭЭЛЭЛ	4
3.3.ХОЁРДУГААР ШАТНЫ АРГА ХЭМЖЭЭНД ОРОЛЦСОН АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГУУДЫГ ШАЛГАРУУЛАХ, ШАГНАЖ УРАМШУУЛАХ, АЛДАРШУУЛАХ 	7
3.3.1. Аж ахуйн нэгж, байгууллагуудыг шалгаруулах	7
3.3.2 Шалгарсан аж ахуйн нэгж, байгууллагуудыг шагнаж.....	11
урамшуулах, алдаршуулах	11
ДӨРӨВ. ҮР ДҮН, САНАЛ ДҮГНЭЛТ	15
ХАВСРАЛТУУД.....	Error! Bookmark not defined.
1 “Давс багатай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжье” арга хэмжээний удирдамж	Error! Bookmark not defined.
Хавсралт 2	Error! Bookmark not defined.
Хавсралт 3	Error! Bookmark not defined.
Хавсралт 4	Error! Bookmark not defined.
Хавсралт 5	Error! Bookmark not defined.
Хавсралт 6.....	2
Хавсралт 7	1
Хавсралт 8	6

“ДАВС БАГАТАЙ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ, ХЭРЭГЛЭЭГ НЭМЭГДҮҮЛЭХ” КОМПАНИТ АЖЛЫН ТАЙЛАН

НЭГ. ҮНДЭСЛЭЛ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Монгол хүн хоногт 11 г давс хэрэглэж байгаа нь ДЭМБ-ын зөвлөмжөөс 2 дахин их, 10 хүн тутмын 8 нь хоногт 5 граммаас их давс хэрэглэж, үйлдвэрийн аргаар боловсруулсан хүнсний бүтээгдэхүүн, хоолны 81.6-83.6% нь давс ихтэй, мөн хүн амын 19.5% нь давс ихтэй хоол, хүнсний талаар ойлголт, мэдлэггүй байсан (“Хүн амын давсны хэрэглээ” судалгаа, ЭМЯ, НЭМҮТ, ДЭМБ, 2013 он).

Нэгдсэн Үндэстний Байгууллагын 2030 он хүртэлх “Тогтвортой хөгжлийн зорилтод 2025 он гэхэд хүн амын давсны хэрэглээг 30% бууруулах”, Монгол Улсын “Давсны хэрэглээг бууруулах” үндэсний стратегид 2025 он гэхэд хүн амын давсны хэрэглээг 2013 оны түвшингээс 30%; хоол, хүнсний давсны агууламжийг 40%-иар бууруулах; мэдээлэл сурталчилгаа, сургалт явуулах замаар хүнс үйлдвэрлэгч, хэрэглэгч, эрүүл мэндийн ажилтны давсны хэрэглээний талаарх мэдлэг, хандлагыг дээшлүүлэхээр тусгагдсан.

НЭМҮТ нь Эрүүл мэндийг дэмжих сангийн санхүүжилт (*ЭМДСангийн 2019 оны 06 сар дугаар сарын 12–ны өдрийн 03 тогтоол, 21^{82.1}-ын 25 дахь заалт*)–ээр “Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэл, хэрэглээг нэмэгдүүлэх” компанит ажлыг “Ажил гүйцэтгэх гэрээ” (*Гэрээ 2019.06.28, №111*)-нд ззасны дагуу нийт 15 сая төгрөгний төсөвт багтаан 2019 оны 6-12 сард ЭМЯ, НЭМҮТ, ХХААХҮЯ, МХЕГ-тай хамтран хэрэгжүүлэв (Хавсралт 1, 2).

ХОЁР. ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Хүн ам, хоол, хүнс үйлдвэрлэгч нарт хүргэх мэдээлэл сурталчилгааны ажлыг өргөжүүлэх замаар давс багатай хоол, хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл хэмжээ, хэрэглээг нэмэгдүүлэхэд энэхүү компанит ажлын зорилго оршиж байв.

Уг зорилгын хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлсэн болно. Үүнд:

1. Мэдээлэл, сурталчилгааны материал боловсруулах, хэвлүүлэх, түгээх,



2. Хоёрдугаар шатны арга хэмжээнд оролцож буй аж ахуйн нэгж, байгууллагуудад сургалт, мэдээлэл хийх,
3. Хоёрдугаар шатны арга хэмжээнд оролцсон аж ахуйн нэгж, байгууллагуудыг шалгаруулах, шагнаж урамшуулах, алдаршуулах.

ГУРАВ. ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

“Давс багатай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хэрэглээг нэмэгдүүлэх” компанит ажлын 3 зорилтын хүрээнд 1) мэдээлэл, сурталчилгааны материал боловсруулах, хэвлүүлэх, түгээх, 2) хоёрдугаар шатны арга хэмжээнд оролцож буй аж ахуйн нэгж, байгууллагуудад сургалт, мэдээлэл хийх, 3) хоёрдугаар шатны арга хэмжээнд оролцсон аж ахуйн нэгж, байгууллагуудыг шалгаруулах, шагнаж урамшуулах, алдаршуулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Үүнд:

3.1. МЭДЭЭЛЭЛ, СУРТАЛЧИЛГААНЫ МАТЕРИАЛ ХЭВЛҮҮЛЭХ, ТҮГЭЭХ

“Давс яагаад хүний биед муу вэ?”, “Давсны хэрэглээг багасгахын ач холбогдол”, “Би хоолны давсаа багасгаж чадна”, “Та мэдэх үү?”, “Та битгий мартаарай” 5 төрлийн зурагт хуудас шинээр боловсруулж тус бүрийг 1000, нийт 5000 ширхэг хэвлэн ЭМЯ, ХХААХҮЯ, НЭМҮТ, НҮБ-ын ХХААБ-аас зохион байгуулсан өдөрлөг, компанит ажил, хэвлэлийн бага хурал, сургалт болон бусад арга хэмжээний үеэр хүн амд түгээж байна (Хавсралт 3)

“Давс багатай хоолны жор, технологи” гарын авлага 260 ширхэг хэвлэгдэн гарсан.

Мэдээлэл сурталчилгааны материалуудыг НЭМҮТ-ийн цахим хуудаст байршуулан хүн амд мэдээлэл сурталчилгаа хийж байна.



Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв



Зурагт хуудас 1



Зурагт хуудас 2




Зурагт хуудас 3



Зурагт хуудас 4



Зурагт хуудас 5




Гарын авлага/ном

3.2. “ДАВС БАГАТАЙ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖЬЕ” АРГА ХЭМЖЭЭНД ОРОЛЦСОН АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГУУДАД ХИЙСЭН СУРГАЛТ, МЭДЭЭЛЭЛ

Нийслэлийн СБД-ийн Үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсээс тус дүүргийн нутаг дэвсгэрийн цэцэрлэг, сургуулийн байгууллага, хүнсний үйлдвэрийн аж ахуйн нэгжийн 75 хүнд хийсэн сургалтанд “Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье” 2-р шатны арга хэмжээний талаар мэдээлэл хийсэн (зураг 1) <http://sbd.gov.mn>



Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв



Зураг 1. СБД-ийн Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгсэдийн сургалт, 2019.03 сар

Нийслэлийн ХУД-ийн Үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтэс 2019 оны 3-р сард Зэвсэгт хүчний 120 дугаар ангид хийсэн сургалтанд оролцсон 315 хүнд “Давсны хэрэглээг багасгах хэрэгцээ, шаардлага” лекц уншиж, давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих арга хэмжээний талаар НЭМҮТ-ийн ХСА (ЭША Б.Энхтунгалаг) мэдээлэл хийсэн.

СБД-ийн 40-р цэцэрлэгээс зохион байгуулсан “Давсны хэрэглээг багасгая” сургалтанд “Хүүхдийн давсны хэрэглээг багасгах хэрэгцээ, шаардлага” сэдвээр НЭМҮТ-ийн ЭША Б.Энхтунгалаг лекц уншиж, мэдээлэл сурталчилгааны материал тараасан (зураг 2, 3).



Зураг 2. “Хүүхдийн давсны хэрэглээг багасгах хэрэгцээ, шаардлага” лекц, Б.Энхтунгалаг, НЭМҮТ, 2019.03.27



Зураг 3. Сурталчилгааны материал түгээлт.



Улаанбаатар төмөр замын харъяа эмнэлэг, хоолны газруудын тогооч, 20 хүнд “Давсны зохистой хэрэглээ” “Хоолны илчлэг тооцох”, зэрэг сэдвээр 2019 оны 05 сарын 24-ний өдөр НЭМҮТ-ийн ХСА (ЭША Б.Энхтунгалаг) хичээл заасан.


ХХААХҮЯ, МХЕГ, МХХ, НЭМҮТ хамтран зохион байгуулсан “Давс багатай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хэрэглээг нэмэгдүүлэх хэрэгцээ, шаардлага” салбар дундын сургалт-семинарт оролцсон 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн 44 мэргэжилтэнд “Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн дэмжье” арга хэмжээний талаар ХХААХҮЯ-ны ХҮБХЗГ-ын дарга Т.Гантогтох, “Давсны зохистой хэрэглээ”, “Давс багатай бүтээгдэхүүн шалгаруулах шалгуур үзүүлэлт”-ийг НЭМҮТ-ийн ХСА (Б.Энхтунгалаг), хоол болон хүнсний бүтээгдэхүүнд лабораторийн шинжилгээний дүнг МХЕГ-ын ЭМХХ-ийн улсын ахлах байцаагч С.Хонгорзул нар тус тус танилцуулсан байна (Зураг 4-6).



Зураг 4. “Давс багатай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хэрэглээг нэмэгдүүлэх хэрэгцээ, шаардлага” салбар дундын сургалт-семинарт оролцогчид. 2019.11.12. “Монголика” зочид буудал



Зураг 5. Б.Энхтунгалаг НЭМҮТ-ийн ХСА-ны ЭША



Зураг 6. Т.Гантогтох ХХААХҮЯ-ны ХҮБХЗГ-ын дарга



3.3.ХОЁРДУГААР ШАТНЫ АРГА ХЭМЖЭЭНД ОРОЛЦСОН АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГУУДЫГ ШАЛГАРУУЛАХ, ШАГНАЖ УРАМШУУЛАХ, АЛДАРШУУЛАХ

3.3.1. Аж ахуйн нэгж, байгууллагуудыг шалгаруулах

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайд, Эрүүл мэндийн Сайдын 2017 оны 09 сарын 07-ны өдрийн А-119, А/355 дугаар тушаал (Хавсралт 4)-аар томилсон “Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье” арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийн хурал 2019 оны 10 сарын 08-ны өдөр ЭМЯ-ны хурлын “Б” танхимд зохион байгуулагдсан.

Хуралд ЭМЯ-ны НЭМГ-ын хоол тэжээл, хунсний аюулгүй байдлын мэргэжилтэн, АУ-ны доктор Б.Бямбатогтох, Эрүүл мэндийн боловсрол, эрүүл мэндийг дэмжих асуудал хариуцсан мэргэжилтэн Ж.Дөлгөөн, ХХААХҮЯ-ны ХҮБХЗГ-ын ХНХХ-ийн мэргэжилтэн Б.Даваадулам, НЭМҮТ-ийн ХСА-ны дарга, АУ-ны доктор Ж.Батжаргал, ЭША Б.Энхтунгалаг, МХЕГ-ын ЭМХХ-ийн улсын ахлах байцаагч Ч.Гантулга, НХХААГ-ын дарга н.Оюунтуяа, Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн нэгдсэн холбооны тэргүүн Ш.Эрдэнэхүү нар оролцож “Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье” 2-р шатны арга хэмжээний явцыг хэлэлцэж, шалгаруулалтыг 2019 оны 11 сарын 15-ны дотор явуулахаар шийдсэн (Зураг 6-7).



Зураг 5. Ажлын хэсгийн хурал.
2019.10.08, ЭМЯ, “Б” танхим

Хуралд “Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье” 2-р шатны арга хэмжээнд оролцсон а.а.н, байгууллагын хоол, хүнсний бүтээгдэхүүний



дээж цуглуулалт, лабораторийн шинжилгээний явцыг МХЕГ-ын ЭМХХ-ийн улсын ахлах байцаагч Ч.Гантулга танилцуулсан (Зураг 7).



Зураг 7. Ч.Гантулга
МХЕГ-ын ЭМХХ-ийн улсын
ахлах байцаагч

“Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье” 2-р шатны арга хэмжээний тайлан ирүүлэх тухай ХХААХҮЯ-ны 01/3551 тоот албан бичгийг аймаг, нийслэлийн ХХААГ-ын дарга нарт 2019 оны 09 сарын 17-нд хүргүүлсэн (Хавсралт 5). Мөн шалгаруулалтыг орон нутагт явлуулж, шалгарсан а.а.н, байгууллагын материалыг 2019 оны 11 сарын 5-ны дотор ирүүлэх тухай аймаг, нийслэлийн ХХААГ-т ХХААХҮЯ үүрэг болгосон.

“Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье” арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийн ээлжит хурал 2019 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр ХХААХҮЯ-ны ХҮБХЗГ-ын дарга Т.Гантогтохын өрөөнд хуралдаж “Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье” 2-р шатны арга хэмжээний нэгдсэн шалгаруулалтад аймаг, нийслэлээс нэр дэвшүүлсэн **29** а.а.н, байгууллагын шалгаруулалтыг явуулсан.

Шалгаруулалтад ХХААХҮЯ-ны ХҮБХЗГ-ын ХНХХ-ийн мэргэжилтэн Б.Даваадулам, МХЕГ-ын ЭМХХ-ийн улсын ахлах байцаагч С.Хонгорзул, НЭМҮТ-ийн ХСА-ны дарга, АУ-ны доктор Ж.Батжаргал, ЭША Б.Энхтунгалаг, ШУТИС-ийн Үйлдвэрлэл, технологийн сургуулийн эрдэмтэн НБД, доктор М.Пүрэвжав, Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах Монголын нийгэмлэгүүдийн нэгдсэн холбооны гүйцэтгэх захирал Ш.Шагзжав нар оролцсон (Зураг 8).



Зураг 8. Шалгаруулах ажлын хэсэг.

2019.11.08, ХХААХҮЯ, 508 тоот

Ажлын хэсгийн гишүүд аймаг орон нутгаас нэр дэвшүүлсэн а.а.н, байгууллагын тайланд ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга 2018 онд баталсан 13 үзүүлэлт, 95 оноо бүхий **“Давс багатай бүтээгдэхүүнийг шалгаруулах шалгуур үзүүлэлт”**-ээр үнэлгээ өгсөн ” (Хавсралт 6).

Ажлын хэсэг нь тэргүүн байр, Гран при “Давсны зохистой хэрэглээг дэмжигч байгууллага”, “Давс багатай гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэгч”, “Давс багатай утсан махан бүтээгдэхүүн үйлдвэрлэгч”, “Давс багатай гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэгч”, “Давс багатай нөөшилсөн ногоо үйлдвэрлэгч” гэсэн 5 номинациар шалгаргуулалтыг явуулсан бөгөөд давсны агууламжийг бууруулсан бүтээгдэхүүний нэр төрөл, тоо, бүтээгдэхүүн дэх давсны агууламж бүтээгдэхүүний давсны агууламжийг бууруулсан хувийг гол шалгуур үзүүлэлт болгосон (Зураг 9, Хавсралт 7).



Зураг 9. Шалгаруулалтын явц



Ажлын хэсгийн үнэлгээ, гишүүдийн 100 хувийн саналаар 92 оноогоор, Тэргүүн байр, Гран при шагнал “Давсны зохистой хэрэглээг дэмжигч байгууллага”-аар Орхон аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв; 91.6 оноогоор “Давс багатай хоол үйлдвэрлэгч”-ээр нийслэл хотоос УБТЗ-ын “Найрамдал” 180-р цэцэрлэг; 90.7 оноогоор орон нутгаас Увс аймгийн 4-р цэцэрлэг, 88.3 оноогоор “Давс багатай гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэгч”-ээр Булган аймгийн “Саруул” нарийн боовны цех, 88.2 оноогоор “Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжигч аймаг”-аар Орхон аймаг (ЗДТГ) тус тус шалгарсан (Зураг 10, Хавсралт 8)



Зураг 10. Шалгарсан 5 аж ахуйн нэгж, байгууллагад олгосон “Батламж”



3.3.2 Шалгарсан аж ахуйн нэгж, байгууллагуудыг шагнаж урамшуулах, алдаршуулах

ХХААХҮЯ, МХЕГ, МХХ, НЭМҮТ хамтран “Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье” 2-р шатны арга хэмжээний шагнал гардуулах ёслолын арга хэмжээг 2019 оны 11 сарын 12-ны өдөр “Монголика” зочид буудалд зохион байгуулсан. Уг арга хэмжээнд 21 аймаг, нийслэлийн 44 төлөөлөгч оролцож, шалгарсан аж ахуйн нэгж байгууллагууд арга хэмжээний хүрээнд хийсэн ажил, хүрсэн үр дүнгээ танилцуулж, туршлагаасаа хуваалцсан.

“Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье” 2-р шатны арга хэмжээнд шалгарсан а.а.н, байгууллагын шагналыг ХХААХҮЯ-ны ХБҮХЗГ-ын дарга, “Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье” арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийн дарга Т.Гантогтох болон МХЕГ, НЭМҮТ, МХХ-ны төлөөлөл гардуулж өгсөн (зураг 11-16).

Шагнал гардуулах ёслолын арга хэмжээ



Зураг 11. Тэргүүн байр “Гран при”, Орхон аймгийн БОЭТ. 2019.11.12



Зураг 12. “Давс багатай хоол үйлдвэрлэгч” Увс аймгийн 4-р цэцэрлэг. “Монголика” зочид буудал. 2019.11.12



Зураг 13. “Давс багатай гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэгч” Булган аймгийн “Саруул”нарийн боовны цех. “Монголика” зочид буудал. 2019.11.12



ураг 14. “Давс багатай хоол үйлдвэрлэгч” УБТЗ-ын “Найрамдал” 180-р цэцэрлэг “Монголика” зочид буудал. 2019.11.12



Зураг 15. “Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжигч аймаг”. Орхон аймаг “Монголика” зочид буудал. 2019.11.12



Зураг 16. Шалгарсан аж ахуйн нэгж, байгууллагууд. Монголика” зочид буудал, 2019.11.12



Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв

“Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье” 2-р шатны арга хэмжээний шалгаруулалтад аймаг, нийслэлээс шалгарсан а.а.н, байгууллагуудад НЭМҮТ-ийн Ерөнхий захирлын 2019 оны А/185 тушаалыг үндэслэн тэргүүн байр-3 сая төгрөг, бусад 4 номинаци тус бүр 1 сая төгрөг, нийт 7 сая төгрөг тухайн а.а.н, байгууллагын дансанд 2019 оны 12 сарын 23-ны өдөр Төрийн банкаар шилжүүлэгдсэн.



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2019 оны 12 сарын 23 өдөр

Дугаар А/185

Улаанбаатар хот

“Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье” 2-р шатны арга хэмжээний шалгаруулалтад аймаг, нийслэлээс шалгарсан аж ахуйн нэгж байгууллагыг шагнаж урамшуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 82 дугаар тогтоол “Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах журам”-ын 2 дугаар хавсралтын 2.3.1, Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийг дэмжих сангийн 2019 оны 03 дугаар тогтоолын хавсралтын 25 дугаар заалт; Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайд, Эрүүл мэндийн Сайдын 2017 оны 09 сарын 07-ны өдрийн А-119, А/355 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар байгуулагдсан “Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье” арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийн 2019 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайд, Эрүүл мэндийн Сайдын 2017 оны 09 сарын 07-ны өдрийн А-119, А/355 дугаар тушаалаар баталсан “Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье” 2-р шатны арга хэмжээний шалгаруулалтад аймаг, нийслэлээс шалгарсан аж ахуйн нэгж байгууллагад олгох шагнал, урамшууллыг хавсралтаар баталсугай.

2. Шагнал, урамшууллыг санхүүжилтийн журмын дагуу холбогдох байгууллагуудад шилжүүлэхийг Санхүү, аж ахуйн хэлтсийн ахлах нягтлан бодогч /А.Болор-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд захирал /Г.Цагаанхүү/-д үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Д.НАРАНТУЯА





Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв


Нийгмийн эрүүл мэндийн ерөнхий
захирлын 2019 оны 12 сарын 16
өдрийн 1/2 тушаалын хавсралт

"Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье" 2-р шатны арга
хэмжээний шалгаруулалтад аймаг, нийслэлээс шалгарсан аж ахуйн
нэгж байгууллагад олгох шагнал, урамшуулал

Д/д	Номинацийн нэр	Шалгарсан аж ахуйн нэгж байгууллагын нэр	Шагналын төрөл	
			Цом, батламж	Мөнгөн шагнал /төг/
1.	Гран при	Орхон аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв	Цом, Батламж	3,000,000
2.	"Давс багатай хоол үйлдвэрлэгч" нийслэлээс	Улаанбаатар Төмөр замын "Найрамдал" 180-р цэцэрлэг	Батламж	1,000,000
3.	"Давс багатай хоол үйлдвэрлэгч" хөдөө орон нутгаас	Увс аймгийн төвийн 4-р цэцэрлэг	Батламж	1,000,000
4.	"Давс багатай талх, нарийн боов үйлдвэрлэгч	Булган аймгийн "Саруул" нарийн боовын цех	Батламж	1,000,000
5.	Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжигч аймаг	Орхон аймгийн ЗДТГ	Батламж	1,000,000
Нийт		5	5	7 000 000



“Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье” 2-р шатны арга хэмжээнд оролцсон болон шалгарсан а.а.н, байгууллагуудыг алдаршуулах, хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр нийтэд сурталчилах ажил хийгдэж байна. Тухайлбал, MNB телевизийн “Өдрийн зочин” хөтөлбөрт 2020 оны 01 сарын 13-ны өдөр НЭМҮТ-ийн ХСА-ны ЭША Б.Энхтунгалаг оролцож ярилцлага өгсөн (Зураг 17).



<https://www.facebook.com/mnbmongoliinmedee/videos/2433573996753366/>

Монголын үндэсний радиод 2020 оны 01 сарын 14-ны өдөр БГД-ийн 83-р цэцэрлэг бүтээгдэхүүний давсны агууламжийг буруулсан туршлага, гарсан үр дүнгийн талаар, НЭМҮТ-ийн ХСА-ны ЭША Б.Энхтунгалаг 2-р шатны арга хэмжээ болон шалгарсан а.а.н байгууллага, давсны зохистой хэрэглээний талаар тус тус ярилцлага өгсөн.

ДӨРӨВ. ҮР ДҮН, САНАЛ ДҮГНЭЛТ

- 1 “Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье” 2-р шатны арга хэмжээнд 2019 онд нийслэлээс 37, хөдөө орон нутгаас 246, нийт 283 аж ахуйн нэгж, байгууллага оролцохоор ХХААХҮЯ-д бүртгүүлснээс 176 (62.2%) нь идэвхтэй оролцсон бөгөөд 1-р шатны арга хэмжээ (2018 он)-тэй харьцуулахад идэвхтэй оролцсон нийт аж ахуй, байгууллага 3.7 дахин (165-аар их), нийслэлээс идэвхтэй оролцсон аж ахуйн нэгж байгууллага 3.4 дахин (26-аар их), давсны агууламжийг бууруулсан хоол, хүнсний бүтээгдэхүүний тоо 2018 онд 43 байсан бол 2019 онд 166 болж 3.9 дахин тус тус нэмэгдсэн.
- 2 МХЕГ-ын лабораторийн шинжилгээний дүнгээр арга хэмжээнд оролцсон аж ахуйн нэгж байгууллагуудын хоол, хүнсэн дэх давсны агууламж 39.6%-иар буурч “Давсны хэрэглээг бууруулах” үндэсний стратегийн хүлээгдэж буй үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг хангасан байна.



Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв

- 3 Нийт 13 төрлийн 17110 ширхэг мэдээлэл сурталчилгааны материал хэвлэн түгээж, мэдээлэл сурталчилгааны материал нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлсэн ба “Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье” 2-р шатны арга хэмжээнд оролцохоор бүртгүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагад НЭМҮТ, ХХААХҮЯ, МХЕГ, аймаг, нийслэлийн ЭМГ, ХХААГ, МХГ-ын мэргэжилтнүүд зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан ба 21 аймаг, нийслэлийн хэмжээнд 2350 хүнд мэдээлэл, зөвлөгөө өгсөн байна.
- 4 НЭМҮТ, ХХААХҮЯ, МХЕГ, аймаг, нийслэлийн ЭМГ, ХХААГ-аас зохион байгуулсан сургалт, хэвлэлийн бага хурал, уулзалт-семинар, ажлын хэсгийн хурал зэрэг арга хэмжээнд 3801 хүн хамрагдаж давсны зохистой хэрэглээний талаарх ойлголт, мэдлэг нь сайжирсан.

ЦААШИД ТАВИХ САНАЛ

- 1 Нөөшилсөн ногооны үйлдвэрлэл, утсан махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэгсэд, үйлдвэр аж ахуйн газруудын дэргэдэх хоолны газар руу чиглэсэн интервенц хэрэгжүүлэх.
- 2 “Давсны хэрэглээг бууруулах” үндэсний стратегийн хэрэгжилтэд дунд шатны үнэлгээ хийх ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулах, ялангуяа стратегийн хэрэгжилтийн гол шалгуур үзүүлэлт болох хүн амын хоногийн давсны хэрэглээг судлах, зах зээлд худалдаалж буй хоол болон хүнсний бүтээгдэхүүний дээж цуглуулах, давсны агууламжид лабораторийн шинжилгээ хийх зэрэг асуудалд ДЭМС санхүүгийн дэмжлэг үзүүлэх.

Нийт зардал: ЭМДС-аас 15 000 000 ₮

Тайлан бичсэн:

Б.Энхтунгалаг, НЭМҮТ-ийн ХСА-ны ЭША

Хянасан:

Ж.Батжаргал, НЭМҮТ-ийн ХСА-ны дарга



Хавсралт 1

"Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэл, хэргэлээг нэмэгдүүлэх" компани ажил зохион байгуулах ажлын гэрээ

2019 оны 6 сарын 28-ний өдөр

№ 111

Улаанбаатар хот

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэхүү Ажил гүйцэтгэх гэрээ (цаашид "Гэрээ" гэх)-г нэг талаас Эрүүл мэндийг дэмжих сан (цаашид "Захиалагч" гэх), түүнийг төлөөлж Нийгмийн эрүүл мэндийн газрын дарга **Т.Энхзаяа**, нөгөө талаас **9045716** регистрийн дугаартай Эрүүл мэндийн яамны харьяа Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (цаашид "Гүйцэтгэгч" гэх), түүнийг төлөөлж захирал **Д.Нарантуяа** нар (цаашид хамтад "Талууд", тус тусад нь "Тал" гэх) Монгол Улсын Иргэний хууль, холбогдох бусад хууль тогтоомж, тогтоол шийдвэр, дүрэм журмыг үндэслэн дараах нөхцөлийг харилцан тохиролцон байгуулав.

1.2 Энэхүү гэрээний дагуу Гүйцэтгэгч Нийгмийн эрүүл мэндийн төвийн захирал **Д.Нарантуяа** ажлыг гэрээнд заасан хугацаанд чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэн Захиалагчид хүлээлгэн өгөх, тайлагнах, нөгөө талаас Захиалагч нь гэрээнд заасан хугацаанд төлбөрийг төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах, талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлага болон тэдгээртэй холбогдсон бусад харилцааг тодорхойлох, зохицуулахад оршино.

ХОЁР.ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

2.1. Гэрээний үйлчлэх хугацаа: **2019/07/01-2019/12/27**

2.2. Хугацааг тоолохдоо гэрээнд тусгайлан зааснаас бусад тохиолдолд хуанлийн тооллыг удирдлага болгоно.

ГУРАВ.ГЭРЭЭНИЙ ҮНЭ, АЖЛЫН ҮЙЛЧИГЭЭНИЙ ТӨЛБӨР

- 3.1. Гэрээний нийт үнийн дүн нь **15,000,000 /арван таван сая/** төгрөг байна. Үүнд НӨАТ болон бусад бүх төлбөр, зардлыг оруулсан болно.
- 3.2. Талууд гэрээ байгуулж, Захиалагч нь Гүйцэтгэгчийн нэхэмжлэлийг хүлээн авснаас хойш ажлын **5** хоногийн дотор **70** хувийн төлбөрийг, Захиалагч ажлын үр дүнг бүрэн хүлээн авч, актаар баталгаажуулснаар үлдэх **30** хувийн төлбөрийг ажлын **5** хоногийн дотор Гүйцэтгэгчийн нэхэмжлэлийг үндэслэн **Төрийн сан** банкны **100900015470** тоот дансанд тус тус шилжүүлнэ.
- 3.3. Гүйцэтгэгч нь гэрээ байгуулсны дараа гэрээний үнийг нэмэгдүүлэх эрхгүй.

ДӨРӨВ. АЖИЛ ХҮЛЭЭЛЦЭХ

- 4.1. Гүйцэтгэгч нь захиалгат ажлыг гүйцэтгэж дуусмагц Захиалагчид үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн хамт хүлээлгэн өгнө.



- 4.2. Захиалагч нь гэрээний зүйлийг шалган баримт/актаар баталгаажуулан хүлээн авна. Уг баримт/акт нь гэрээний салшгүй хэсэг болно.

ТАВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

5.1. Захиалагчийн эрх, үүрэг:

- 5.1.1. Захиалагч нь Гүйцэтгэгчид гэрээний зүйлд заасан ажлыг гүйцэтгэх ажлын даалгавар баталж өгөх, шаардлагатай мэдээллээр хангах үүрэгтэй.
- 5.1.2. Захиалагч нь Гүйцэтгэгчийн ажлын хөлсийг гэрээнд заасны дагуу төлөх үүрэгтэй.
- 5.1.3. Захиалагч нь гүйцэтгэсэн ажлын үр дүнг гэрээнд заасан хугацаанд хүлээн авах үүрэгтэй.
- 5.1.4. Захиалагч нь ажлын гүйцэтгэлийн явц, үр дүнг шалгах эрхтэй. Ажлын даалгаварт зааснаас зөрүүтэй болон стандартын шаардлага хангаагүй тохиолдолд хүлээн авахаас татгалзах, дахин гүйцэтгэхийг шаардах, шаардлагыг хүлээн аваагүй тохиолдолд 3 дагч этгээдээр гүйцэтгүүлэх, үүнтэй холбогдон гарсан зардлыг Гүйцэтгэгчээр нөхөн төлүүлэх (төлөх ёстой төлбөрөөс суутган авах) эрхтэй.
- 5.1.5. Гүйцэтгэгч нь шаардлага хангаагүй гэрээний зүйлийг үнэ төлбөргүй буюу өөрийн зардлаар дахин/нөхөж гүйцэтгэх боломжгүй буюу гэрээнд заасан хугацаанд амжихгүйгээр хугацаа алдсан тохиолдолд Захиалагч ажлын төлбөрийг төлөхгүй байх эрхтэй.
- 5.1.6. Гүйцэтгэгч гэрээний үүргээ хоёр ба түүнээс дээш удаа биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй эсхүл гэрээнд заасан ажил, үр дүнг хүлээлгэн өгөх боломжгүй болсон тохиолдолд төлбөр төлөхөөс татгалзан, гэрээг нэг талын санаачилгаар цуцлах эрхтэй.
- 5.1.7. Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэгтэй.

5.2. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг:

- 5.2.1. Гэрээгээр хүлээсэн ажил, үүргийг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартын дагуу мэргэжлийн өндөр түвшинд хийж гүйцэтгэн гэрээнд заасан хугацаанд Захиалагчид хүлээлгэн өгөх үүрэгтэй.
- 5.2.2. Гүйцэтгэсэн ажлын үр дүнг Захиалагчид хүлээлгэн өгөхөөс өмнө ажлын үр дүнд учирч болох эрсдэлийг дангаар хариуцах үүрэгтэй.
- 5.2.3. Гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн гэрээний ажил нь Захиалагчийн баталсан ажлын даалгавраас зөрсөн, өөрчлөгдсөн, чанарын шаардлага хангаагүй тохиолдолд тухайн шаардлага хангаагүй гэрээний зүйлсийг дахин үнэ төлбөргүй хийж гүйцэтгэх үүрэгтэй.
- 5.2.4. Гүйцэтгэгч нь энэхүү гэрээнд заасан үүргээ биелүүлээгүйгээс Захиалагч болон гуравдагч этгээдэд учирсан аливаа хохирлыг дангаар хариуцан арилгах үүрэгтэй.
- 5.2.5. Захиалагчийн бичгээр гаргасан зөвшөөрөлгүйгээр гэрээгээр хүлээсэн үүргээ бусад этгээдэд шилжүүлэхгүй байх үүрэгтэй.
- 5.2.6. Мөнгөн урьдчилгааны тайлан болон анхан шатны баримтууд 2019 оны 12 дугаар сарын 01-ний өдөрт багтаан Эрүүл мэндийн яамны төсвийн ерөнхий нягтлан бодогч, биелэлт гүйцэтгэлийн тайлан ЭМДС-ийн мэргэжилтэнд хүргүүлэх үүрэгтэй.



- 5.2.7. Эрүүл мэндийг дэмжих сангийн санхүүжилтээр зохион байгуулсан, бүтээсэн, аливаа арга хэмжээ, бүтээлд Эрүүл мэндийг дэмжих сангийн нэрийг дурдах үүрэгтэй.
- 5.2.8. Гүйцэтгэгч нь гэрээний ажил үйлчилгээний төлбөрийг гэрээнд заасны дагуу төлөхийг шаардах эрхтэй.
- 5.2.9. Ажил гүйцэтгэхтэй холбогдуулан нэмэлт мэдээлэл авах эрхтэй.
- 5.2.10. Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэгтэй.

ЗУРГАА. ТАЛУУДЫН ХАРИУЦЛАГА

- 6.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгөөгүй буюу чанарын доголдлыг тогтоосон хугацаанд арилгаагүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутам гүйцэтгээгүй ажлын үнийн дүнгийн 0,01 хувиар алданги тооцно.
- 6.2. Алданги төлсөн нь талуудыг гэрээнд заасан үүргээ гүйцэтгэх, учирсан хохирлыг нөхөн төлөхөөс чөлөөлөх үндэслэл болохгүй.
- 6.3. Төслийн ажлын даалгавар, үйл ажиллагааны календарчилсан төлөвлөгөө энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.

ДОЛОО. ГЭНЭТИЙН БУЮУ ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 7.1. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн улмаас захиалагч буюу гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ зохих хугацаанд хийж гүйцэтгээгүй бол шаардлагатай хугацаагаар түүнийг гүйцэтгэх хугацааг сунгаж болно.
- 7.2. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер г.м байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн, эсэргүүцлийн хөдөлгөөн, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио цээр г.м талуудын хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдлыг ойлгоно.
- 7.3. Бараа материал, түүхий эдийн хомсдлын улмаас бий болсон үнийн өсөлт, үйлдвэрлэгч болон бараа нийлүүлэгчийн шийдвэр, хязгаарлалт нь гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлд хамаарахгүй.

НАЙМ. НУУЦ ХАДГАЛАХ БА БАТАЛГАА

- 8.1. Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж мэдсэн байгууллага, хувь хүний нууцад хамаарах аливаа мэдээ мэдээллийг бусдад бичгэн буюу аман хэлбэрээр задруулах, гэрээнд зааснаас өөр зорилгоор ашиглах эрхгүй.
- 8.2. Нууц хадгалахтай холбоотой үүргээ зөрчсөн тал нөгөө талдаа учруулсан хохирлыг бүрэн хариуцна.
- 8.3. Энэ заалт нь ажил гүйцэтгэгчийн бүх ажилтан, төлөөлөгчид болон туслан гүйцэтгэгч /хэрэв байгаа бол/ нарт нэгэн адил хамаарна.

ЕС. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 9.1. Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал, зөрөлдөөн, маргааныг талууд зөвшилцөх аргаар эвийн журмаар шийдвэрлэнэ.
- 9.2. Хэрэв маргаанаа зөвшилцөх аргаар шийдвэрлэж чадахгүйд хүрвэл Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.



- 10.1. Гэрээ нь талуудын бүрэн эрхт төлөөлөгчид гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болж, гэрээг цуцалснаар буюу гэрээний нөхцөл бүрэн биелэгдсэнээр дуусгавар болно.
- 10.2. Гэрээ нь талуудын эрх ашиг, сонирхлын төлөө байгуулагдсан бөгөөд талуудын хувьд зайлшгүй дагаж мөрдөх баримт бичиг мөн.
- 10.3. Аль нэг талын хүсэлтээр гэрээний нөхцөлд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага гарвал талууд харилцан тохиролцож, зөвшилцсөний үндсэн дээр гэрээнд бичгээр нэмэлт, өөрчлөлт оруулах бөгөөд энэ нь гэрээний салшгүй хэсэг байна.
- 10.4. Гэрээнд тусгагдаагүй бусад асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.
- 10.5. Гэрээг монгол хэл дээр 4 хувь үйлдэж, хувь тус бүр хууль зүйн адил хүчинтэй байна.

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЕРӨНХИЙ
ЗАХИРАЛ Д.НАРАНТУЯА

2019 он 06 сар 28 өдөр

Хянасан:

О. Санжаасугар
С.Санжаасугар, Хуулийн
зөвлөх

Боловсруулсан:

Ж.Батжаргал, НЭМҮТ-ийн
ХСА-ны дарга

Б.Энхтунгалаг, НЭМҮТ-ийн
ХСА-ны ЭША



“Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэл, хэрэглээг нэмэгдүүлэх”

компанит ажлын зардлын төсөв

Д/д	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа		Давтамж, тоо	Тайлбар /хэмжих нэгж /	Нэгж үнэ /төгрөг/	Нийт үнэ /төгрөг/
1	“Давс багатай хоолны жор” ном хэвлүүлэх	Материал боловсруулах	1	60 хуудас	5,000	300,000
		Хянах	1	60 хуудас	5,000	300,000
		Эх бэлтгэх	1	60 хуудас	5,000	300,000
		Хэвлүүлэх зардал	260ш	60 хуудас	300	4,680,000
Дүн						5,580,000
2	Зурагт хуудас, инфографик хэвлүүлэх	Эх загвар гаргах	5	төрөл	30,000	150,000
		Претест хийх	5	20 хүн	3,000	300,000
		Хэвлүүлэх зардал	5 төрөл	1000 ш	300	1,500,000
Дүн						1,950,000
3	Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэгч аж ахуйн нэгж байгууллагыг шалгаруулах, шагнаж урамшуулах	Гран при	1	1	3,000,000	3,000,000
		Давс багатай утсан махан	1	1	1,000,000	1,000,000
		бүтээгдэхүүн үйлдвэрлэгч				
		Давс багатай нөөшилсөн ногоо	1	1	1,000,000	1,000,000
		үйлдвэрлэгч				
		Давс багатай хоол үйлдвэрлэгч	1	1	1,000,000	1,000,000
		Давс багатай талх, нарийн боов үйлдвэрлэгч	1	1	1,000,000	1,000,000
		Өргөмжлөл,	1	5	80,000	400,000
		Цом	1	1	70.000	70,000
Дүн						7,470,000
НИЙТ ДҮН						15,000,000

Хавсралт 3

“Эрүүл хүнс-эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөр
Өглөөний цай хөдөлгөөн Ээжийн сонголт-эрүүл хүнс
хөдөлгөөн нэгдсэн хэлэлцүүлэг арга хэмжээнд ХХААХҮЯ-нд хуваарилсан
материал

№	Материалын нэр	Материалын төрөл	Хүлээн авсан хүний нэр, албан тушаал	Тоо ширхэг
1	“Та битгий мартаарай”	инфографик	Дамбаатар	100
2	“Би хоолны давсаа багасгж чадна”	инфографик	Дамбаатар	100
3	“Шаржигнуур төмс, бэлэн гоймон, кетчуп бага хэрэглэхийн учир шалтгаан та мэдэх үү”	инфографик	Дамбаатар	100
4	“Давсны хэрэглээгээ багасгахын ач холбогдол”	инфографик	Дамбаатар	100
5	“Давс яагаад хүний эрүүл мэндэд муу вэ?”	инфографик	Дамбаатар	100
6	Давсны хэрэглээ ба хүүхдийн эрүүл мэнд зөвлөмж	МСС-ын багц	Дамбаатар	4
7	Хоолны давсыг юугаар орлуулж болох вэ?	Зурагт хуудас	Дамбаатар	100
8	Давсны зохистой хэрэглээг дэмжье	Зурагт хуудас	Дамбаатар	100

704

Материал түгээсэн:

Дамбаатар

Д.Ганболор



Хавсралт 4

ХҮНС ХӨДӨӨ АЖ АХҮЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД,
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2017 оны .09 дугаар
сарын .04-ны өдөр

Дугаар А-119/А/355

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн "Давс иоджуулж иод дутлаас сэргийлэх тухай хууль", 2015 оны Засгийн газрын 353 дугаар тогтоолоор батлагдсан "Давсны хэрэглээг бууруулах" үндэсний стратеги (2015-2025), 2015 оны 447 дугаар тогтоолоор баталсан "Хүн амын хоол тэжээл" (2015-2025) үндэсний хөтөлбөрийн 4.1.2 дахь заалтыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Давсны зохистой хэрэглээг хэвшүүлэх зорилгоор "Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье" арга хэмжээг орон даяар 2017 оны 09 дүгээр сараас эхлүүлэн 2 үе шаттайгаар зохион байгуулсугай.

2. Арга хэмжээг зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Аяныг зохион байгуулахад шаардагдах зардлыг холбогдох байгууллагын жил бүрийн төсвөөс санхүүжүүлж, арга хэмжээний төлөвлөгөөны явцын үр дүнг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан тайлагнахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга нарт үүрэг болгосугай.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХҮЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН
САЙД

П.СЭРГЭЛЭН

ЭРҮҮЛ МЭНДИЙН
САЙД

А.ЦОГЦЭЦЭГ

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн
үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн
сайдын хамтарсан тушаал 2017
оны 09 дугаар сарын 07-ны
өдрийн 4/А дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт

**"ДАВС БАГАТАЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖЬЕ"
АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ**

Нэг. Үндэслэл

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ) дэлхийн хүн амын давсны хэрэглээг 2025 он гэхэд 30 хувиар бууруулах, үүний тулд үндэсний стратеги, төлөвлөгөө хэрэгжүүлэх, хүнс болон хоол үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний давсны агууламжийг бууруулахын зэрэгцээ хүнсний давсыг иоджуулж хүн амыг иод дутлын эмгэг (ИДЭ)-ээс сэргийлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэхийг гишүүн орнуудын засгийн газарт зөвлөмж болгосон (ДЭМБ, 2012).

Швейцарийн Женев хотноо 2013 онд зохион байгуулсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын 66 дахь хуралдаанаар баталсан "Ерөнхий Ассамблейн Халдварт бус өвчний урьдчилан сэргийлэлт, хяналтын асуудлаарх өндөр хэмжээний уулзалтын улс төрийн тунхаглал"-д хүнсний давсны агууламжийг бууруулах, үр ашигтай арга хэмжээ авч хэрэгжүүлэх (43.7), эрүүл хүнсний үйлдвэрлэлийг дэмжих, боломжийн үнээр хүртээмжтэй болгох, хүнсний шошгын стандартыг мөрдөх, ялангуяа давсны агууламжийн тухай мэдээллийг тодорхой заах (44.2), давсны хэрэглээг бууруулах зорилгоор хүнсний үйлдвэрлэлд давс хэрэглэхийг хязгаарлах (44.5) гэж тус тус заасан (ДЭМБ, 2014).

Монгол хүн хоногт 11.1 г буюу ДЭМБ-ын зөвлөмж хэмжээнээс 2 дахин их давс хэрэглэдэг; хүнсний бүтээгдэхүүний шошгын шим тэжээлийн мэдээлэлд давсны хэмжээг тусгадаггүй; үйлдвэрийн аргаар боловсруулсан хүнсний 83.6 хувь, хоол үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний 81.6 хувь нь давсны агууламж ихтэй болохыг 2011-2012 онд Эрүүл мэндийн яам, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Монголын мянганы сорилтын сан хамтран хийсэн "Хүн амын давсны хэрэглээ" үндэсний судалгааны дүн харуулсан байна.

Монгол улс 1996–2010 онд иодын дутлын эмгэг (ИДЭ)-ээс сэргийлэх 2 удаагийн үндэсний хөтөлбөр, 2003 онд "Давсыг иоджуулж, иодын дутлын сэргийлэх тухай" хуулийг батлан хэрэгжүүлсний үр дүнд ИДЭ-ийн тархалт 29.2 хувиас 7.3 хувь хүртэл 3 дахин буурч, иоджуулсан давс хэрэглэдэг өрхийн эзлэх хувь 54.4 хувиас 89.1 хувь болж өссөн. Гэвч сүүлийн жилүүдэд иоджуулсан давсны дотоодын үйлдвэрлэл эрс буурч, 90 гаруй хувийг импортын давс эзэлж байна. Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын 2014 онд хийсэн хяналт шалгалтаар иоджуулсан давсны нийт дээжийн 35 хувь нь иодын агууламжгүй, 50 хувь нь стандартад заасан хэмжээнээс бага иодын агууламжтай гарсан байна.



Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв

Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, "Хүн амын хоол тэжээл үндэсний хөтөлбөр" (2016-2020), "Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн баримтлах бодлого", "Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн" зорилтын хүрээнд хүн амын дунд давсны зөв зохистой хэрэглээг хэвшүүлэх, иоджуулсан давсны ач холбогдлыг сурталчлах, давс багатай хүнс болон хоол үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн, түүнчлэн иоджуулсан давсны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, давсны чанар, аюулгүй байдалд тавих хяналтыг сайжруулах зэрэг тодорхой арга хэмжээ тусгагдсан.

Монгол улсын Засгийн газрын 2015 оны 353 дугаар тогтоолоор батлагдсан "Давсны хэрэглээг бууруулах" үндэсний стратеги (2015-2025)-д үйлдвэрийн аргаар боловсруулсан бүтээгдэхүүн, нийтийн хоолны давсны агууламжийг тус тус 40 хувь бууруулах арга хэмжээ авах, давс багатай хүнс, хоолны үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээг дэмжих, нийтэд сурталчлан таниулах үйл ажиллагааг аймаг, нийслэл, сум дүүргийн түвшинд авч хэрэгжүүлэхээр тусган баталсан ч хэрэгжилтийн үр дүн хангалтгүй байна.

Иймээс "Давс багатай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжье" арга хэмжээг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ), Эрүүл мэндийн яам (ЭМЯ), Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (НЭМҮТ), Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (МХЕГ), Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба (УБЗАА), Нийслэлийн хүнс, хөдөө аж ахуйн газар (НХХААГ), Нийслэлийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг (НХЭАХН), Шинжлэх ухаан технологийн их сургууль (ШУТИС)-ийн төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг хамтран зохион байгуулахаар төлөвлөж байна.

Хоёр. Зорилго, зорилт

2.1. Үйлдвэрийн аргаар боловсруулсан хүнс болон хоол үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний давсны агууламжийг бууруулахад аж ахуйн нэгжийг татан оролцуулах замаар давс багатай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, түүнчлэн иоджуулсан давсны дотоодын үйлдвэрлэл, чанар аюулгүй байдлын хяналтыг сайжруулахад уг аяны зорилго оршино.

2.2 Арга хэмжээний хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлж байна:

1. Үйлдвэрийн аргаар боловсруулсан хүнс болон нийтийн хоол үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний давсны агууламжийг бууруулахад эрдэм шинжилгээний байгууллага, мэргэжлийн холбоод, үйлдвэрлэгч, эрдэмтэд болон олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх;
2. Хүнсний бүтээгдэхүүн болон хоол үйлдвэрлэлд хэрэглэх давсны хэмжээг багасгах;
3. Иоджуулсан давсны дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх;
4. Хүнсний импорт, боловсруулсан хүнс болон хоол үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний давсны агууламж, иоджуулсан давсны чанарт тавих хяналтыг сайжруулах;
5. Иргэдэд давсны ач холбогдол, зохистой хэрэглээний мэдлэг, дадлыг хэвшүүлэх бий болгох замаар хүн амын давсны хэрэглээг бууруулах;



Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв

Гурав. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.1. Давс багатай хүнсний бүтээгдэхүүн болон хоолны үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлэх чиглэлээр:

3.1.1. Нийгмийн эрүүл мэндэд хувь нэмэр оруулж буй үйлдвэрлэгч (хүнсний бүтээгдэхүүн болон хоол) аж ахуйн нэгжийг сурталчлан таниулах;

3.1.2. Үйлдвэрлэгч аж ахуйн нэгжид давс багатай бүтээгдэхүүн болон хоол үйлдвэрлэлийн чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагаар дамжуулан арга зүйн зөвлөгөө өгөх, шаардлагатай гэж үзвэл сургалт явуулах;

3.1.3 Үйлдвэрлэгч аж ахуйн нэгжийн зах зээлд худалдан борлуулж буй бүтээгдэхүүнүүдийн дээжийг цуглуулан давсны агууламжийг лабораторийн нөхцөлд тодорхойлж, үнэлгээ, дүгнэлт өгөх;

3.2. Иоджуулсан давсны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх чиглэлээр:

3.2.1. Иоджуулсан давс үйлдвэрлэгчдэд иодын бэлдмэлийг нийлүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

3.2.2. Иоджуулсан давсны үйлдвэрлэлд ашиглагдах тоног төхөөрөмжийг гаалийн албан татвараас чөлөөлөх;

3.2.3. Иоджуулсан давсны хяналт шалгалтыг тогтмол явуулж, илэрсэн зөрчил дутагдлыг бууруулах;

3.3. Иргэдэд давсны ач холбогдол, хэрэглээний талаар мэдлэг, хандлагыг дээшлүүлэх чиглэлээр:

3.3.1. Олон нийтэд чиглэсэн давсны ач холбогдол, зохистой хэрэглээг хэвшүүлэхэд чиглэсэн сургалт, хэлэлцүүлэг, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах;

3.3.2. Иоджуулсан давсны хэрэглээг нэмэгдүүлэхэд иргэдэд сургалт, сурталчилгаа зохион байгуулах;

3.3.3. Олон нийтэд арга хэмжээтэй холбоотой мэдээ, мэдээллийг танилцуулж, мэдээлэх;

Дөрөв. Зохион байгуулах хугацаа, үе шат

4.1. Арга хэмжээг дараах 2 үе шаттайгаар зохион байгуулна:

4.1.1. Нэгдүгээр шат – 2017 оны 9 дүгээр сараас эхлэн 2018 оны 4 дүгээр сар хүртэл;

4.1.2. Хоёрдугаар шат – Үндэсний хэмжээнд 2018 оны 4 дүгээр сараас эхлэн 2019 оны 4 дүгээр сар хүртэл.

Тав. Санхүүжилт

5.1. Арга хэмжээг зохион байгуулахад шаардлагатай санхүүжилтийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Эрүүл мэндийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Шинжлэх ухаан технологийн их сургууль, Нийслэл, аймаг орон нутгийн засаг даргын тамгын газар, Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Хүнс, хөдөө аж, ахуйн

газар, Монголын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгүүдийн нэгдсэн холбооны тухайн жилийн батлагдсан төсвөөс санхүүжүүлэх;

5.2. Оролцогч аж ахуйн нэгж байгууллагууд шалгаруулалтад бүтээгдэхүүнээ оролцуулахтай холбогдох (дээж авах, лабораторийн шинжилгээ, шинэ жор турших) зардал бүрэн хариуцна.



Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн
үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн
сайдын хамтарсан тушаал 2017 оны
09 дугаар сарын 27-ны
өдрийн Ажл. Мэрг. дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт

"ДАВС БАГАТАЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖЬЕ" АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:

- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга

Орлогч дарга:

- Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн газрын дарга

Нарийн бичгийн дарга:


- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн
- Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хоол судлалын албаны хүнсний аюулгүй байдлын асуудал хариуцсан эрдэм шинжилгээний ажилтан

Гишүүд:

- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Худалдаа, нийтийн хоол үйлчилгээний зохицуулалтын хэлтсийн дарга
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хяналт, шинжилгээ үнэлгээний газрын мэргэжилтэн
- Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн газрын хоол тэжээл, хүнсний аюулгүй байдлын асуудал хариуцсан мэргэжилтэн
- Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн газрын эрүүл мэндийг дэмжих сангийн асуудал хариуцсан мэргэжилтэн
- Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Эрүүл мэндийн хяналтын хэлтсийн дарга
- Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Эрүүл мэндийн хяналтын хэлтсийн улсын ахлах байцаагч
- Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хоол судлалын албаны дарга
- Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн
- Нийслэлийн засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хүнсний үйлдвэрлэлийн хэлтсийн дарга
- Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн дарга
- Монголын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгүүдийн нэгдсэн холбооны дарга
- Монголын хүнсчдийн холбоо
- Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн нэгдсэн холбоо



Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв



"ДАВС БАГАТАЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖЬЕ" АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах байгууллага
1.	Арга хэмжээг хүнсний бүтээгдэхүүн болон хоол үйлдвэрлэгч аж ахуйн нэгж байгууллагуудад танилцуулах уулзалт зохион байгуулах	2017.09-р сар	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
2.	Давс багатай бүтээгдэхүүн шалгаруулах шалгуур үзүүлэлт боловсруулах	2017.10-р сар	Ажлын хэсэг
3.	Арга хэмжээнд оролцох аж ахуйн нэгжийг бүртгэх	2017.11-р сар	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
4.	I шатны шалгаруулалтад нэр дэвшүүлсэн бүтээгдэхүүн болон хоолны дээжийг цуглуулж, давсны агууламжид лабораторийн шинжилгээ хийх	2017.11, 12-р сар	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
5.	Иоджуулсан давсны асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулах	2017.11-р сар	Эрүүл мэндийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
6.	Давс багатай бүтээгдэхүүний шинэ жор боловсруулах	2017.11-р сар	Шинжлэх, ухаан технологийн их сургууль, аж ахуй нэгж байгууллагууд
7.	Давс багатай хоолны жорыг турших, нэвтрүүлэх	2017.12-р сараас	Аж ахуй нэгж байгууллагууд
8.	Давсны гарал үүсэл, натрийн агууламжийг судлах	2018.01-р сараас	Шинжлэх ухаан технологийн их сургууль
9.	Хоол үйлдвэрлэлдээ давсны агууламжийг бууруулсан жишиг цэцэрлэг бий болгох	2018.01-р сараас	Шинжлэх ухаан технологийн их сургууль
10.	Давсны агууламжийг бууруулсан бүтээгдэхүүн болон хоолноос дээж цуглуулж, лабораторийн шинжилгээ хийх	2018.01-р сар	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв



Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв

11.	Бүтээгдэхүүн болон хоолны давсны агууламжийн лабораторийн шинжилгээний дүнг нэгтгэх	2018.02-р сар	Ажлын хэсэг
12.	Давс талаарх мэдээлэл сурталчилгааны 7 хоногийг зохион байгуулах	2018.02, 03-р сар	Ажлын хэсэг
13.	Арга хэмжээний I шатны шалгаруулалтыг дүгнэх	2018.03-р сар	Ажлын хэсэг
14.	Шалгарсан аж ахуйн нэгжид шагнал гардуулах, алдаршуулах	2018.03-р сар	Ажлын хэсэг
15.	Арга хэмжээний II шатны шалгаруулалтын уралдааныг зарлах	2018.04-р сар	Ажлын хэсэг, аймаг орон нутг засаг даргын тамгын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газар
16.	Арга хэмжээний II шатны шалгаруулалтад оролцох аж ахуйн нэгжүүдийг бүртгэх	2018.05-р сар	Аймгийн засаг даргын тамгын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газар
17.	II шатны шалгаруулалтад нэр дэвшсэн хүнсний бүтээгдэхүүн болон хоолны дээжийг цуглуулж, давсны агууламжид лабораторийн шинжилгээ хийх	2018.06-09-р сар	Аймаг, орон нутгийн мэргэжлийн хяналтын газар
18.	Давс багатай бүтээгдэхүүн болон хоолны жорыг турших, нэвтрүүлэх	2018.06-р сараас	Аж ахуй нэгж байгууллагууд
19.	Давсны агууламжийг бууруулсан бүтээгдэхүүн болон хоолноос дээж цуглуулж, лабораторийн шинжилгээ хийх	2018.09-11-р сар	Аймаг орон нутгийн мэргэжлийн хяналтын газар
20.	Бүтээгдэхүүн болон хоолны давсны агууламжийн лабораторийн шинжилгээний дүнг нэгтгэх	2019.01-р сар	Ажлын хэсэг
21.	Арга хэмжээний II шатны шалгаруулалтыг дүгнэх	2019.02-р сар	Ажлын хэсэг, аймаг орон нутгийн Засаг даргын тамгын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газар
22.	Давс талаарх мэдээлэл сурталчилгааны 7 хоногийг зохион байгуулах	2019.02, 03-р сар	Ажлын хэсэг, аймаг орон нутгийн засаг даргын тамгын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Эрүүл мэндийн



Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв

			газар, Мэргэжлийн хяналтын газар
23.	Шалгарсан аж ахуйн нэгжид шагнал гардуулах, алдаршуулах	2019.03-р сар	Аймаг орон нутгийн Засаг даргын тамгын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газар
24.	Эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулах	2019.03-р сар	Эрүүл мэндийн яам, Нийгмийн эрүүл мэндийн төв, Нийслэлийн засаг даргын тамгын газар, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Хүнс, хөдөө аж ахуйн газар
25.	Зах зээлд худалдаалж буй иоджуулсан давсан дахь иодын агууламжид хяналт тавьж, дүгнэлт гаргах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах	2017-2019 он	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
26.	Мэдээлэл сурталчилгааны материал боловсруулах, хэвлэх	2017-2019 он	Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газар
27.	Хэрэгжилтийн явцын талаар олон нийтэд мэдээлэх /жилд 2 удаа/	2017-2019 он	Ажлын хэсэг
28.	2 жилийн арга хэмжээний үр дүнг гаргаж, олон нийтэд танилцуулах	2019.5 сар	Ажлын хэсэг


**МОНГОЛ УЛСЫН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**
 13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
 Энхтайвны орлон ногоо 16а, Засгийн газрын IX байр,
 Утас: 26 22 71, Факс: (976-51) 26 32 37,
 И-мэйл: mofa@mofa.gov.mn, Вэбсайт: www.mofa.gov.mn

2019.09.17 № 01/3551
 ТАНАЙ _____ -ийн № _____ -т

**АЙМГУУДЫН ХӨДӨӨ АЖ АХУЙН
ГАЗРЫН ДАРГА НАРТ**

“Давсны хэрэглээг бууруулах” үндэсний стратегийг хэрэгжүүлэх зорилгоор “Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье” хоёрдугаар шатны арга хэмжээг 2019 оны 1 дүгээр сараас зохион байгуулан 21 аймаг, нийслэл хотод үйл ажиллагаа явуулж буй хүнс, хоол үйлдвэрлэгч аж ахуйн нэгж байгууллагыг өөрсдийн хүсэлтээр оролцуулан, тодорхой нэр төрлийн хоол, хүнсний бүтээгдэхүүний давсны агууламжийг бууруулахаар ажиллаж байна.

Энэхүү арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийн хурлын шийдвэрийн дагуу шалгаруулалтыг энэ оны 10 дугаар сарын сүүлийн 7 хоногт явуулахаар төлөвлөж байгаа тул уг арга хэмжээний хүрээнд хийсэн ажлын урьдчилсан тайланг бидэнд ирүүлнэ үү.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
 АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ,
 ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
 ГАЗРЫН ДАРГА  Т.ЖАМБАЛЦЭРЭН

00004381



Хавсралт 6

БАТЛАВ:
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АХИБАН ХҮРГИЙГ ТҮР
ХАРИУЦАГЧ БӨГӨӨД ТӨРИЙН ЗАХИРЛААНЫ УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА Д.ЭНХБАТ

“ДАВС БАГАТАЙ БҮТЭЭГДЭХҮҮН”-ИЙГ ШАЛГАРУУЛАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛЭ

Нэг. Нийтлэг зүйл

- 1.1. Үйлдвэрийн аргаар боловсруулсан давс багатай хүнс болон хоол үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг шалгаруулахад энэхүү удирдамжийг мөрдөнө.
- 1.2. Шалгаруулалтад “Давс багатай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжье” арга хэмжээнд оролцохоор материалаа ирүүлж, бүртгүүлсэн аж ахуйн нэгжүүд оролцоно.
- 1.3. Давс багатай бүтээгдэхүүн шалгаруулахад эхний үе шатанд нийслэл, 2 дох үе шатанд орон нутгийн хэмжээнд үйлдвэрийн аргаар боловсруулсан хүнс болон хоол үйлдвэрлэгч аж ахуй нэгж, тэдгээрийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн хамрагдана.
- 1.4. Шалгаруулалтыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд болон Эрүүл мэндийн сайд нарын 2017 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн А/119, А/355 хамтарсан тушаалын хоёрдугаар хавсралтаар байгуулагдсан “Давс багатай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжье” арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн уг удирдамжийн хавсралт 2-д заасан 13 шалгуур үзүүлэлтээр шалгаруулж, дүгнэнэ. Шалгуур үзүүлэлтийн нийт оноо 95 байна.
- 1.5. Шалгаруулалтыг “Давс багатай талх, гурилан бүтээгдэхүүн”, “Давс багатай махан бүтээгдэхүүн”, “Давс багатай нөөшилсөн ногоо”, “Давс багатай хоол”, “Давс орлуулагч, хүнсний шинэ жор технологи”, “Давс багатай хоол үйлдвэрлэгч”, “Давсны зохистой хэрэглээг дэмжигч байгууллага” гэсэн 7 номинациар шалгаруулж, шагнал олгоно.
- 1.6. Шалгаруулалтын явцыг жил бүрийн 3 сард зохион байгуулагдах “Давсны талаарх мэдлэгийг дээшлүүлэх” мэдээлэл сурталчилгааны 7 хоногийн үеэр нийтэд зарлаж, сурталчилна.

Хоёр. Арга хэмжээнд оролцох сонирхлоо илэрхийлэх аж ахуйн нэгжид тавигдах шаардлага

- 2.1. Хүнс бүтээгдэхүүн, хоол үйлдвэрлэлийн чиглэлээр 3-аас доошгүй жил тогтмол үйл ажиллагаа явуулж буй, улсын бүртгэлийн гэрчилгээтэй байна.
- 2.2. Эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангасан барилга байгууламж, тоног төхөөрөмж, мэргэшсэн ажилтан, ажиллагсадтай байна.
- 2.3. Мэргэжлийн хяналтын байгууллагад бүртгэлтэй байна.



Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв

- 2.4. Бүтээгдэхүүний үйлдвэрлэлд дэвшилтэт техник, жор технологи нэвтрүүлсэн, үйл ажиллагаандаа зохистой дадлыг хэрэгжүүлж ажилладаг байна.
- 2.5. Шалгаруулалтад бүтээгдэхүүнээ оролцуулахтай холбогдох (дээж авах, лабораторийн шинжилгээ, шинэ жор турших, сурталчилгаа хийх) зардлыг бүрэн хариуцна.
- 2.6. Нийгмийн хариуцлагын хүрээнд холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран хэрэглэгчдийн хоол хүнс, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, хоол, хүнсний бүтээгдэхүүнийг эрүүл зохистой зөв хэрэглэх талаарх мэдлэг, мэдээлэл олгох сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах төлөвлөгөөтэй байна.
- 2.7. Шалгаруулалтад оролцох аж ахуйн нэгж хавсралт I-ийн дагуу холбогдох материалыг бүрдүүлсэн байна.

Гурав. Шалгаруулалтад нэр дэвшүүлэх бүтээгдэхүүнд тавигдах шаардлага

- 3.1. Давсыг нь бууруулахаар нэр дэвшүүлж буй хүнсний бүтээгдэхүүн, хоол нь сүүлийн 3-аас доошгүй жил үйлдвэрлэн, хэрэглэгчдийн сэтгэлд нийцсэн, байнгын хэрэглээ болсон байна.
- 3.2. Хүнсний бүтээгдэхүүн болон хоол нь холбогдох стандарт батлагдсан жор технологийн зааврын дагуу үйлдвэрлэгдэж, чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан байна.
- 3.3. Бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд итгэмжлэгдсэн лабораторит шинжлүүлж, шинжилгээний дүнг хавсаргана.
- 3.4. Бүтээгдэхүүний давсны агууламжид "Нийгмийн эрүүл мэндийн Үндэсний төвийн дэргэдэх Шим тэжээл судлалын лаборатори"-г шинжилгээ хийлгэж, үр дүнг баталгаажуулсан байна.

Дөрөв. Шалгаруулах шалгуур үзүүлэлт

- 4.1. Хүнсний бүтээгдэхүүн болон хоолны давсны агууламжийг бууруулах шинэ жор, технологийг санаачлан нэвтрүүлсэн байна.
- 4.2. Хоол хүнсээр дамжих өвчин /хоолны хордлого/-тэй холбоотой зорчил гаргаагүй байна.
- 4.3. Хүнсний бүтээгдэхүүн болон хоолны давсны агууламжийг 40 хувиас доошгүй бууруулсан, үр дүн нь лабораторийн шинжилгээгээр баталгаажсан байна.
- 4.4. Хүнсний бүтээгдэхүүний шошго, хоолны цэсэнд 100 г-д агуулагдах давсны хэмжээг бичиж тэмдэглэсэн байна.
- 4.5. Хооллох танхимд давсны хэрэглээтэй холбоотой анхааруулга, зөвлөмж, мэдээлэл байршуулсан байна.
- 4.6. Үйлдвэрийн ажилчдад олгож буй хоолны давсны агууламжийг бууруулах арга хэмжээ авч үр дүнг тооцсон байна.
- 4.7. Давсны зохистой хэрэглээний талаарх байгууллагын ажилчдын мэдлэг, хандлагыг дээшлүүлж үр дүнг тооцсон байна.
- 4.8. Удирдамжийн 2.6-д заасны дагуу үйл ажиллагаа явуулж, тайланг хавсаргасан байна.



Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв

4.9. Давс багатай хүнсний бүтээгдэхүүн, хоол үйлдвэрлэгчийг хавсралт №2-г заасан шалгуурын дагуу нийт 95 онооны шалгуур үзүүлэлтээр шалгаруулж дүгнэнэ.

Тав. Шагналын төрөл

Шалгаруулалтад оролцогч аж ахуйн нэгж байгууллага, бүтээгдэхүүнийг дараах хүснэгтэд дурдсан 7 номинацаар 2018 оны 9 дүгээр сард, 2019 оны 3 дугаар сард тус тус шалгаруулна.

Д/д	Номинацын нэр	Номинацын тоо, оноор		Шагнал	Шагнал хариуцах байгууллага
		2018	2019		
1.	Давс багатай талх, гурилан бүтээгдэхүүн	1	2	Батламж, тус бүр 1 сая төгрөг	ХХААХҮЯ, Аймгийн ЗДТГ, ХХААГ, Улаанбаатар хотын ЗАА, Мэргэжлийн Хяналтын газар
2.	Давс багатай утсан махан бүтээгдэхүүн	1	2	Батламж, тус бүр 1 сая төгрөг	ХХААХҮЯ, Аймгийн ЗДТГ, ХХААГ, Улаанбаатар хотын ЗАА, Мэргэжлийн Хяналтын газар
3.	Давс багатай ноошилсон ногоо	-	2	Батламж, тус бүр 1 сая төгрөг	ХХААХҮЯ, Аймгийн ЗДТГ, ХХААГ, Улаанбаатар хотын ЗАА, Мэргэжлийн Хяналтын газар
4.	Давс багатай хоол	1	2	Батламж, тус бүр 1 сая төгрөг	ХХААХҮЯ, Улаанбаатар хотын ЗАА
5.	“Давс орлуулагч” хүнсний шинэ жор технологи	-	1	Батламж, тус бүр 2 сая төгрөг	ХХААХҮЯ
6.	Давсны зохистой хэрэглээг дэмжигч байгууллага, Гран при	1	1	Цом, тус бүр 3 сая төгрөг	ЭМЯ, Эрүүл мэндийг дэмжих сан, ДЭМБ
7.	Давс багатай хоол үйлдвэрлэгч	1	1	Тэмдэглэгээ/лого/	ХХААХҮЯ, Улаанбаатар хотын ЗАА
Нийт		6	11		



Хавсралт 1

**ДАВС БАГАТАЙ БҮТЭЭГДЭХҮҮН ШАЛГАРУУЛАЛТАД ОРОЛЦОХ АЖ АХУЙН
НЭГЖИЙН БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ**

1. Арга хэмжээнд оролцох хүсэлт
2. Улсын бүртгэлийн гэрчилгээ
3. Мэргэжлийн хяналтын байгууллагад бүртгэлийн гэрчилгээ
4. Тухайн бүтээгдэхүүнийг сүүлийн 3 жилд үйлдвэрлэж борлуулсан тоо хэмжээ болон бүтээгдэхүүний чанарын үзүүлэлт
5. Хоол хүнсээр дамжих өвчин /хоолны хордлого/-тэй холбоотой зөрчил гаргаагүйг батлах баримт бичиг
6. Шалгаруулалтад бүтээгдэхүүнээ оролцуулахтай холбогдох (дээж авах, лабораторийн шинжилгээ, шинэ жор турших) зардлыг бүрэн хариуцах баталгаа
7. Байгууллага болон бүтээгдэхүүний танилцуулга каталог /орц найрлага, технологи ажиллагаа/
8. Үйлдвэрлэлд дэвшилтэт техник, технологи нэвтрүүлсэн баталгаа, баримт бичиг
9. Нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө
10. Давс багатай бүтээгдэхүүний талаар явуулах мэдээлэл сурталчилгааны агуулга



ШАЛГАРУУЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

№	Шалгуур үзүүлэлтүүд	Оноо	Тайлбар
1.	Давсны агууламжийг бууруулсан хүнсний бүтээгдэхүүн, хоолны нэр төрөл, Нийт 10 оноо - 5-аас дээш: 10 оноо - 5 хүртэл: 5 оноо - Байхгүй: 0 оноо		
2.	Шинээр нэвтрүүлсэн жор технологийн тоо, Нийт 10 оноо - 5-аас дээш: 5 оноо - 5 хүртэл: 3 оноо - Байхгүй: 0 оноо		
3.	Бүтээгдэхүүний 100 г-д агуулагдах давсны хэмжээ, Нийт 10 оноо - Давсгүй: 10 оноо - 0,1г хүртэл: 8 оноо - 0,1-0,3 г: 3 оноо - 0,3-0,6 г: 1 оноо - 0,6 г-аас их: 0 оноо		
4.	Бүтээгдэхүүний давсны агууламжийг бууруулсан хувь, Нийт 10 оноо - 40 хувиас дээш: 10 оноо - 31-40 хувь: 8 оноо - 21-30 хувь: 6 оноо - 20 хувь хүртэл: 3 оноо - Буураагүй: 0 оноо		
5.	Хоол хүнсээр дамжих өвчин /хоолны хордлого/-тэй холбоотой зөрчил, Нийт оноо 1 - Гаргаагүй: 1 оноо - Гарсан бол: - 20 оноо		
6.	Бүтээгдэхүүн болон хоолны жор технологийн баталгаажуулалт, Нийт 5 оноо - Стандартын байгууллагаар баталгаажуулсан бол: 5 оноо - Үгүй бол: 0 оноо		
7.	Бүтээгдэхүүний шошго дээрх шим тэжээлийн мэдээлэл, Нийт 10 оноо - Шим тэжээлийн мэдээлэл MNS 6648: 2016 үндэсний шаардлагад бүрэн нийцсэн бол: 5 оноо - Дутуу бол: 2 оноо - Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/221 тушаалаар батлагдсан "Хүнсний бүтээгдэхүүний сав боодлын нүүрэн хэсэгт шим тэжээлийн мэдээллийг байршуулах заавар"-ын дагуу бүтээгдэхүүний шошгын нүүрэн хэсэгт давсны агууламжийн талаар мэдээлэл байршуулсан бол: 5 оноо - Үгүй бол: 0 оноо		



Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв

8.	Хоолдох танхимд давсны хэрэглээтэй холбоотой анхааруулга, зөвлөмж, мэдээлэл, Нийт 1 оноо - Мэдээлэл байршуулсан: 1 оноо - Үгүй: 0 оноо		
9.	Өөрийн үйлдвэрийн ажилчдын давсны хэрэглээг бууруулах арга хэмжээний үр дүн, Нийт 10 оноо - Сургалтын давтамж - o 3-аас дээш удаа: 3 оноо - o 3 хүртэл удаа: 0.5 оноо - o Сургалт хийгдээгүй: 0 оноо - Нийт ажилчдын сургалтад хамрагдсан хувь - o 80 хувиас дээш: 2 оноо - o 61-80 хувь: 1 оноо - o 60 хувиас доош: 0.5 оноо - Давсны агууламжийг бууруулсан хоолны нэр төрөл - o 5-аас дээш: 5 оноо - o 5 хүртэл: 3 оноо - o Байхгүй: 0 оноо		
10.	Хэрэглэгчдийн дунд явуулсан мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажил, Нийт 10 оноо - ТВ шторк: 5 оноо - Олон нийтийг хамарсан арга хэмжээ: 3 оноо - Цахим мэдээлэл: 2 оноо - Хийгдээгүй: 0 оноо		
11.	Хэвлүүлсэн мэдээлэл, сургалт, сурталчилгааны материал, Нийт оноо 8 - Гарын авлага: 5 оноо - Санамж: 2 оноо - Зурагт хуудас: 1 оноо - Байхгүй: 0 оноо		
12.	Удирдамжийн 2.6-д заасан ажлын төлөвлөгөөний биелэлт, Нийт 5 оноо - 91-100 хувь: 5 оноо - 81-90 хувь: 4 оноо - 71-80 хувь: 3 оноо - 61-70 хувь: 1 оноо - 60 хувиас доош: 0.5 оноо - Төлөвлөгөө байхгүй: 0 оноо		
13.	Бүтээгдэхүүний талаарх хэрэглэгчийн сэтгэл ханамжийн байдал, Нийт 5 оноо - Маш сайн: 5 оноо - Сайн: 3 оноо - Дунд: 1 оноо - Хангалтгүй: 0 оноо		
Нийт 95 оноо			

Хавсралт 7

"Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье" 2-р шатны арга хэмжээнд оролцсон а.а.н, байгууллагын хоол, хүнсний бүтээгдэхүүний давсны агууламж (МХЕГ-ын лабораторийн шинжилгээний дүн)

Д/д	Аймаг, дүүрэг, аж ахуйн нэгж, байгууллагын нэр		Бүтээгдэхүүний нэр	Давсны агууламж (г/100г)			Буурсан үзүүлэлт	
				I	II	III	Грамм	Хувь
1	Архангай	1-р цэцэрлэг	1- Төмсний хучмал	0.85		0.45	0.40	47.1
			2- Овьёосны бантан	0.76		0.58	0.18	23.7
			Дундаж	0.81		0.52	0.29	36.0
Аймгийн дундаж			2	0.81		0.52	0.29	36.0
2	Баян-Өлгий	Цэнгэл Хайрхан ХХК (Арвин ресторан)	1- Бор будааны бантан	0.82		0.64	0.18	21.5
			2- Шинэ ногооны салат	1.22		0.64	0.58	47.3
			3- Баяжуулсан бууз	1.34		0.70	0.64	47.6
			4- Цай	3.06		0.38	2.68	87.6
			5- Зутан	1.11		1.05	0.06	94.6
			6- Гуляш	0.92		0.30	0.62	67.4
			Дундаж	1.41		0.62	0.79	56.1
Аймгийн дундаж			6	1.11		0.57	0.54	48.8
3	Булган	Саруул НБЦ	1- Амтлаг боов	0.16	0.10	0.06	0.20	88.5
			2- Цайны боов		0.16	0.11	0.05	31.3
			3- Сүүт нарийн боов	0.20	0.14	0.10	0.24	85.3
			4- Боорцог	0.10	0.09	0.07	0.12	81.6
			5- Мини бялуу	0.16	0.11	0.06	0.21	88.9
			6- Кекс	0.28		0.09	0.19	67.9
			Дундаж	0.18	0.12	0.08	0.17	54.6
		6-р цэцэрлэг	1- Будаатай хуурга	0.20				
			2- Гурилтай шөл	0.20				
			3- Сүүтэй шар будаа	0.30				
			4- Боов	0.40				
			5- Ааруулын шүүс	0.00				
			Дундаж	0.22				
		1-р сургууль	1- Боов	0.20				
			2- Цай	0.00				
			3- Ногоотой шөл	0.40				
			4- Кембаб	1.00				
			5- Гоймонтой шөл	0.40				
			Дундаж	0.40				
Аймгийн дундаж			16	0.27	0.12	0.08	0.19	69.4
4	Говь-Алтай	Аймгийн нэгдсэн эмнэлэг	1- Хөц будаатай шөл	0.04				
			2- Цуйван	1.30				
			Дундаж	1.30				
Аймгийн дундаж			2	1.30				
5	Говьсүмбэр	6-р цэцэрлэг	1- Кимбаб	0.60		0.40	0.20	33.3
			2- Ногоотой шөл	0.60		1.20	-0.60	-100.0
			3- Котлет	1.00		0.90	0.10	10.0
			Дундаж	0.73		0.83	-0.10	-13.6
Аймгийн дундаж			3	0.73		0.83	-0.10	-13.6



Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв

Үргэлжлэл....

Д/д	Аймаг, дүүрэг, аж ахуйн нэгж, байгууллагын нэр		Бүтээгдэхүүний нэр	Давсны агууламж (г/100г)			Буурсан үзүүлэлт	
				I	II	III	Грамм	Хувь
6	Дархан	Мөнх Ундрам Хүнс ХХК	1- Фитнесс талх		1.50	0.50	1.00	66.7
			2- Жигнэмэг		1.80	0.90	0.90	50.0
			3- Сархан боов		2.00	0.60	1.40	70.0
			Дундаж		1.77	0.67	1.10	62.3
		5-р цэцэрлэг						
Аймгийн дундаж			3		1.77	0.67	1.10	62.3
7	Дорнод	14-р цэцэрлэг	1- Хөц будаатай шөл	0.47				
			2- Мантуутай хуурга	0.22				
			3- Ногоотой шөл					
			4- Лапшатай холимог хуурга	0.34		0.43	-0.09	-26.5
			5- Гурилтай шөл	0.38				
			6- Ногоотой хуурга	0.57				
			Дундаж	0.40		0.43	-0.03	-8.6
		12-р сургууль	1- Хунзан бууз	0.50				
			2- Гоймонтой хуурга	0.48		0.27	0.21	43.8
			3- Будаатай хуурга	0.44		0.43	0.01	2.3
			4- Бантан	0.53				
			5- Будаатай шөл	0.52				
			6- Гурилтай шөл	0.48				
			7- Мантуун бууз	0.42				
			Дундаж	0.48		0.35	0.11	27.3
		9-р цэцэрлэг	1- Тэжээллэг зутан	0.41		0.50	-0.09	-22.0
			2- Элэгний котлет,	0.55				
			3- Төмсний нухаш	0.55				
			4- Алаг гоймонтой хуурга	0.39				
			5- Эрдэнэшишийн ногоон зутан	0.47				
			6- Тефтель	0.28				
			Дундаж	0.42		0.50	-0.08	-19.0
		"Баян тал" цех	1- Салами	2.32		0.89	1.43	
			2- Давхар утлагат	1.98	1.20	0.77	2.41	
			Дундаж	2.15	1.20	0.83	1.92	61.4
Аймгийн дундаж			21	0.86	1.20	0.53	0.33	38.8
8	Дорноговь	3-р цэцэрлэг	1- Улаан лоольтой шөл	0.16		0.70	-0.54	-337.5
			2- Цуйван	0.94		0.40	0.54	57.45
			Дундаж	0.55		0.55	0.00	0.0
		"Гайхамшигт андууд" ХХК	1- Будаатай хуурга	0.75		0.50	0.25	33.3
			Дундаж	0.75		0.50	0.25	33.3
Аймгийн дундаж			3	0.65		0.53	0.25	19.2



Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв

Үргэлжлэл....

Д/д	Аймаг, дүүрэг, аж ахуйн нэгж, байгууллагын нэр		Бүтээгдэхүүний нэр	Давсны агууламж (г/100г)			Буурсан үзүүлэлт		
				I	II	III	Грамм	Хувь	
9	Завхан	3-р цэцэрлэг	1- Хачир төмс нухаш	0.30					
			2- Холимог жимс ундаа	0.00					
			3- Жимстэй боов	0.00					
			4- Хүрэн манжин хачир	0.20					
			5- Хярам	0.01	0.03	0.00	0.04	100.0	
			6- Манжин, лууван, махтай зутан	0.30					
			7- Хөөрүүлсэн сүү	0.02	0.15	0.00	0.17	100.0	
			8- Гуляш	0.10					
			9- Чанасан гоймон	0.01					
			10- Сүүтэй будаа	0.08		0.02	0.02	75.0	
			11- Хүрэн манжин, ногоотой шөл	0.3					
			12- Жигнэсэн банш	0.2					
			13- Сүүн зутан	0.1					
			14- Бууз	0.06					
			15- Баяжуулсан шөл	0.20					
			16- Буржгар гоймонтой сүү	0.02					
			17- Үзэмний ундаа	0.01					
			18- Тэргүүн гурилан боов	0.62					
		Дундаж			0.12	0.09	0.01	0.11	94.4
		4-р цэцэрлэг	1- Ногоотой шөл	0.82		0.40	0.42	51.2	
			2- Бууз	1.10					
			3- Гурилтай шөл	0.40		0.20	0.20	50.0	
			4- Будаатай хуурга	0.70					
			Дундаж			0.76		0.30	0.31
Аймгийн дундаж			22	0.44		0.15	0.28	64.9	
10	Орхон	Бүсийн оношилгоо эмчилгээний төв	1- Бууз	0.80	0.40	0.40	0.80	83.3	
			2- Гоймонтой шөл	3.20	0.20	0.15	3.25	97.8	
			3- Будаатай хуурга	0.50	0.40	0.20	0.70	88.9	
			4- Гуляш	0.20	0.10	0.10	0.20	83.3	
			5- Борш	0.40	0.20	0.06	0.54	95.0	
			6- Бантан		0.50	0.35	0.15	30.0	
			7- Байцаатай шөл		0.20				
			8- Хүүхдийн будааны каша		0.10				
			9- Гурвалжин будааны каша		0.10				
			10- Байцаатай хуурга	0.15					
			11- Гурвалжин будааны зутан	0.10					
			Дундаж			0.76	0.24	0.20	0.56
		"Орхон Энхбүтэмж" ХХК	1- "Эрдэнэт" зайдас	0.70					
			2- "Тайхар" хагас уталгат хиам	0.60					
			3- "Залуус" чанамал хиам	0.63					
			4- "Салями" бүтэн уталгат хиам	0.80					
			Дундаж			0.68			
Аймгийн дундаж			15	0.72	0.24	0.20	0.52	72.1	



Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв

Үргэлжлэл....

Д/д	Аймаг, дүүрэг, аж ахуйн нэгж, байгууллагын нэр		Бүтээгдэхүүний нэр	Давсны агууламж (г/100г)			Буурсан үзүүлэлт	
				I	II	III	Грамм	Хувь
11	Өвөрхангай	Уянга сумын цэцэрлэг	1- Гурилтай шөл	1.20		0.29	0.91	75.8
			2- Ногоотой бууз	1.60				
			3- Бөөрөнхий мах, ногоотой шөл	1.30				
			4- Цуйван	1.30		0.34	0.96	73.8
			5- Цөцгийтэй талх	0.20				
			6- Боорцог	0.20		0.11	0.09	45.0
			7- Бууз	0.34				
			8- Ногоотой шөл	0.31				
			9- Цөцгийтэй тостой талх	0.05				
		Дундаж	0.72		0.25	0.48	65.8	
		4-р цэцэрлэг	1- Цуйван	1.20		0.80	0.40	33.3
			2- Төмсний хучмал	1.50	1.03		0.47	31.3
			3- Бууз	1.30		1.18	0.12	9.2
			4- Баяжуулсан бантан	3.40		1.60	1.80	52.9
			5- Аарцтай гурилтай шөл	3.60				
			6- Ногоотой шөл	0.86		0.50	0.36	41.9
			7- Ногоо, гурвалжин будаатай шөл	1.08		0.70	0.38	35.2
			8- Үзэмтэй талх	0.22	0.33		-0.11	-50.0
			9- Ороомгон боорцог	0.15	0.26		-0.11	-73.3
			10- Гурилтай шөл	1.45				
			Дундаж	1.48	0.54	0.96	0.52	35.2
Аймгийн дундаж			19	1.10	0.54	0.96	0.14	13.0
12	Өмнөговь	4-р цэцэрлэг	1- Шар будаатай шөл	0.56				
			2- Цуйван		1.16	1.36	-0.20	-17.2
			3- Цагаан будаатай шөл	1.25				
			Дундаж	0.91	1.16	1.36	-0.20	-17.2
Аймгийн дундаж			3	0.91	1.16	1.36	-0.46	-17.2
13	Сүхбаатар	Оточ болор эмнэлэг	1- Бууз	0.50		0.40	0.10	20.0
			2- Гурилтай шөл	0.50		0.20	0.30	60.0
			Дундаж	0.50		0.30	0.20	40.0
		11-р цэцэрлэг	1- Гуляш	2.00				
			2- Гурилтай шөл	1.20				
			Дундаж	1.60				
Аймгийн дундаж			4	1.05		0.30	0.75	71.4
14	Сэлэнгэ							
			Дундаж					
Аймгийн дундаж								
15	Хэнтий	4-р цэцэрлэг	1- Гурилтай шөл	0.87		0.58	0.29	33.3
			2- Соустай бөөрөнхий мах	0.97		0.78	0.19	19.6
			Дундаж	0.92		0.68	0.24	26.1
		4-р сургууль	1- Гоймонтой шөл	0.97		0.63	0.34	35.1
			2- Бантан	0.98		0.75	0.23	23.5
			3- Мушгиа гоймонтой шөл	1.00		0.84	0.16	16.0
			Дундаж	0.98		0.74	0.24	24.7
		"Гэрэлт хэрлэн" ХХК	1- Тахиан махан ороомог, хиам	2.00		1.45		27.5
			Дундаж	2.00		1.45		27.5
			Аймгийн дундаж			6	1.30	

Үргэлжлэл....



Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв

Д/д	Аймаг, дүүрэг, аж ахуйн нэгж, байгууллагын нэр		Бүтээгдэхүүний нэр	Давсны агууламж (г/100г)			Буурсан үзүүлэлт	
				I	II	III	Грамм	Хувь
16	Ховд	"Хишиг эрдэнэ баяжих" ХХК	1- Долоон од	2.10		1.33	0.77	36.7
			2- Саями	1.90		1.50	0.40	21.1
			3- Аялал хиам	1.80		1.14	0.66	36.7
			4- Зайдас	1.70		1.03	0.67	39.4
			Дундаж	1.88		1.25	0.63	33.3
Аймгийн дундаж			4	1.88		1.25	0.63	33.3
17	Увс	4-р цэцэрлэг	1- Цуйван	0.51				
			2- Цагаан будаатай шөл	0.29		0.10	0.19	65.5
			3- Ногоотой хуурга	0.30				
			4- Баяжуулсан бантан	0.50	0.06	0.12	0.44	76.0
			5- Ногоотой хуурга	0.23				
			6- Бууз	0.70		0.30	0.40	57.1
			7- Ногоотой шөл	0.30				
			8- Хайлмаг	0.00				
			9- Цэлцэгнүүр	0.00				
			Дундаж	0.31	0.06	0.17	0.14	44.9
Аймгийн дундаж			9	0.31	0.06	0.17	0.14	44.9
18	Хөвсгөл	Титаник ХХК	1-Буриад талх Титаник					
			2-Хөх тарианы хар талх					
Аймгийн дундаж			2					
19	УБ, Баянгол дүүрэг	180-р цэцэрлэг	1- Цоо байцаатай шөл		0.12	0.03	0.09	75.0
			2- Брокли цэцэгт байцаатай шөл		0.14	0.03	0.11	78.6
			3- Амталсан будаатай бөөрөнхий мах		0.13	0.03	0.10	76.9
			4- Битүү чанасан мах ногоо		0.13	0.03	0.10	76.9
			5- Шар хулуутай ногооны зутан		0.25	0.04	0.21	84.0
			6- Өргөст хэмх далайн байцааны зутан		0.10	0.03	0.07	70.0
			7- Талх		0.75	0.03	0.72	96.0
			8- Аяган кейк		0.38	0.03	0.35	92.1
			Дундаж		0.25	0.03	0.22	87.5
		94-р цэцэрлэг	1- Хулууны зутан	0.70				
			2- Байцаатай хуурга	1.60				
			3- Бор будаатай хуурга	0.20				
			4- Бууцайтай шөл	0.20				
			5- Хулууны зутан	0.20				
			6- Бууз	0.29				
			7- Тефтель	0.29				
			8- Броклитой шөл	0.14				
			9- Будаатай шөл	0.13				
			10- Гурилтай шөл	0.14				
			11- Гоймонтой шөл	0.14				
			12- Мах байцааны зутан	0.14				
			13- Эрдэнэшишийн ногоон зутан	0.14				
			14- Цэцэгт байцаа будааны зутан	0.14				
			15- Тахианы зутан	0.70				
			Дундаж	0.34				
20	Чингэлтэй дүүрэг	224-р цэцэрлэг	1- Гурилтай шөл	0.14				
			2- Ногоотой хуурга	0.73				
			3- Гоймонтой шөл	0.14				
			4- Талх	0.42				
			Дундаж	0.36				
Нийслэлийн дундаж			27	0.35	0.25	0.03	0.32	91.1
УЛСЫН ДУНДАЖ			166	0.95		0.57	0.37	39.6



Хавсралт 8

“ДАВС БАГАТАЙ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖЬЕ” АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ *Дугаар 03/2019*

2019 оны 11-р сарын 08

Улаанбаатар хот

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайд, Эрүүл мэндийн Сайдын 2017 оны 09 сарын 07-ны өдрийн А-119, А/355 дугаар тушаалаар байгуулсан “Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье” арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийн хурлыг ХХААХҮЯ-ны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (ХҮХБЗГ)-ын дарга Т.Гантогтохын ажлын өрөөнд 2019 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 13.00 минутад эхлэж 15.30 минутад дуусгав. Хуралд ХХААХҮЯ-ны ХҮБХЗГ-ын дарга Т.Гантогтох, Худалдаа, нийтийн хоолны хэлтсийн мэргэжилтэн Б.Даваадулам, МХЕГ-ын Эрүүл мэндийн хяналтын хэлтсийн улсын ахлах байцаагч С.Хонгорзул, НЭМҮТ-ийн Хоол судлалын албаны дарга Ж.Батжаргал, эрдэм шинжилгээний ажилтан Б.Энхтунгалаг, Нийслэлийн Захирагчийн ажлын албаны Хүнсний худалдаа, үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэн Я.Бадмаа, ШУТИС-ийн Хүнсний үйлдвэрлэл, технологийн сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн дарга М.Пүрэвжав, Монголын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгүүдийн үндэсний холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Шагжжав, Монголын Хүнсчдийн холбооны менежер А.Цэцгээ нар оролцов.

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ:

“Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье” 2-р шатны арга хэмжээний шалгаруулалтад аймаг, нийслэлээс нэр дэвшүүлсэн аж ахуйн нэгж байгууллагыг дүгнэж, шалгаруулах.

СОНССОН НЬ:

Аймаг, нийслэлийн ХХААГ-аас ХХААХҮЯ-д ирүүлсэн албан бичиг, нэр дэвшүүлсэн аж ахуйн байгууллагын тайлан, шалгаруулах үнэлгээний хуудсыг ХХААХҮЯ-ны ХҮХБЗГ-ын ХНХХ-ийн мэргэжилтэн, ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Б.Даваадулам танилцуулав.

“Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье” 2-р шатны арга хэмжээний төлөвлөгөө, 2019 онд оролцсон аж ахуйн нэгж байгууллагын тоо, “Эрүүл мэндийг дэмжих сан”-гаар дэмжигдсэн төсөв болон шалгаруулах номинацийг НЭМҮТ-ийн Хоол судлалын албаны ЭША, ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Б.Энхтунгалаг танилцуулав. Арга хэмжээнд оролцохоор бүртгүүлсэн аж ахуйн нэгж байгууллагын бүтээгдэхүүний давсны агууламжид



аймаг, нийслэлийн мэргэжлийн хяналтын газраас хийсэн лабораторийн шинжилгээтэй холбоотой асуудлыг МХЕГ-ын Эрүүл мэндийн хяналтын хэлтсийн улсын ахлах байцаагч С.Хонгорзул танилцуулав.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

ХХААХҮЯ-ны баталсан “Давс багатай бүтээгдэхүүнийг шалгаруулах шалгуур үзүүлэлт”-ийн дагуу 13 үзүүлэлтээр аймаг орон нутгаас нэр дэвшүүлсэн аж ахуйн нэгж байгууллагын тайланд ажлын хэсгийн гишүүд 95 хүртэлх оноогоор үнэлгээ өгч дараах 5 номинациар шалгаруулав. Үүнд:

1. Гран при, Давсны зохистой хэрэглээг дэмжигч байгууллага
2. Давс багатай утсан махан бүтээгдэхүүн үйлдвэрлэгч
3. Давс багатай гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэгч
4. Давс багатай нөөшилсөн ногоо үйлдвэрлэгч
5. Давс багатай хоол үйлдвэрлэгч

“Давс багатай утсан махан бүтээгдэхүүн үйлдвэрлэгч”, “Давс багатай нөөшилсөн ногоо үйлдвэрлэгч” номинацид тэнцэх аж ахуйн нэгж байгууллага байсангүй.

Ажлын хэсгийн гишүүдийн үнэлгээний дүнг нэгтгэхэд 92 оноогоор Орхон аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв”, 81.6 оноогоор Улаанбаатар төмөр замын “Найрамдал” 180-р цэцэрлэг, 80.7 оноогоор Увс аймгийн 4-р цэцэрлэг, 78.3 оноогоор Булган аймгийн “Саруул” нарийн боовны цех, 78.2 оноогоор Орхон аймаг тус тус шалгарсан.

Ажлын хэсгийн гишүүд 100 хувийн саналаар Гран при шагнал “Давсны зохистой хэрэглээг дэмжигч байгууллага”-аар Орхон аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв; “Давс багатай хоол үйлдвэрлэгч”-ээр нийслэл хотоос УБТЗ-ын “Найрамдал” 180-р цэцэрлэг; орон нутгаас Увс аймгийн 4-р цэцэрлэг, “Давс багатай гурилан бүтээгдэхүүн” үйлдвэрлэгчээр Булган аймгийн “Саруул” нарийн боовны цех шалгарсан бол арга хэмжээг дэмжигч байгууллагаар Орхон аймгийн ЗДТГ тус тус шалгарсан.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Хурлын тэмдэглэлийг ажлын хэсгийн гишүүдэд хүргүүлэх /ХХААХҮЯ, Б.Даваадулам/
2. Арга хэмжээнд оролцсон аж ахуйн нэгж байгууллагын бүтээгдэхүүний давсны агууламжид аймаг, нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын хийсэн лабораторийн шинжилгээний дүнг нэгтгэж НЭМҮТ-д файлаар өгөх /МХЕГ, Ч.Гантулга, С.Хонгорзул/.
3. Шалгарсан аж ахуйн нэгж байгууллагын нэхэмжлэх холбогдох материалыг бүрдүүлж НЭМҮТ-ийн Санхүү, аж ахуйн хэлтэст өгч шийдвэрлүүлэх /ХХААХҮЯ, Б.Даваадулам, НЭМҮТ, Б.Энхтунгалаг/



Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв

4. Шалгаруулалтын дүнг 2019 оны 11 сарын 12-13-ны өдөр “Монголика” зочид буудалд болох “Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэл, хэрэглээг нэмэгдүүлэх хэрэгцээ, шаардлага” 21 аймгийн ХХААГ-ын мэргэжилтнүүдийн салбар дундын уулзалтад танилцуулах /ХХААХҮЯ, Т.Гантогтох, Б.Даваадулам/.
5. Шалгарсан аж ахуйн нэгж байгууллагад олгох “Батламж”, “Цом”-ийн эх загвар гаргах, хэвлүүлэх /НЭМҮТ, Б.Энхтунгалаг/.
6. Шалгарсан аж ахуйн нэгж байгууллагыг алдаршуулах арга хэмжээг 2019 оны 12 сард зохион байгуулах /НЭМҮТ, Ж.Батжаргал, Б.Энхтунгалаг/.
7. Компанит ажлын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан гаргаж ЭМДС-д хүлээлгэн өгөх /НЭМҮТ, Б.Энхтунгалаг/.

Тэмдэглэл хөтөлсөн:

Б.Даваадулам, ХХААХҮЯ-ны ХҮБХЗГ-ын
НХХ-ийн мэргэжилтэн, Ажлын хэсгийн
нарийн бичгийн дарга,

Б.Энхтунгалаг, НЭМҮТ-ийн ХСА-ны
ЭША, Ажлын хэсгийн нарийн бичгийн
дарга

Танилцсан:

Т.Гантогтох, ХХААХҮЯ-ны ХҮБХЗГ-ын
дарга, Ажлын хэсгийн дарга